

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/066/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99041524 Цахим хаяг: <a href="mailto:tsetsegmaab@audit.gov.mn">tsetsegmaab@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 7048-4030,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 25 № 102

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨГРӨГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.МЯНГАНБАЯР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Төсвийн төсөлд тусгаагүй 17,424.0 мянган төгрөгийн хоолны нөхөх төлбөр, 25,653.8 мянган төгрөгийн урамшууллын зардал гаргасан,
- Гамшгийн бэлэн байдлын хувцас бэлтгэхэд 5,100.0 мянган төгрөг зарцуулсан,
- Төрийн албаны шалгалт өгөөгүй, түр томилгоотой албан хаагчдад 13,050.7 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон,
- Тайлант онд байгууллагын эзэмшлийн буудлын орлого 1,179.0 мянган төгрөгийг байгууллагын үндсэн дансанд төвлөрүүлэлгүй, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан,
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүн зөрүүтэй, тооцоог бодоогүй байна.

822505000293

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд зарцуулалтын эрхийг нээж өгөөгүйгээс шалтгаалан 8,328.0 мянган төгрөгийн зөөврийн усны тээвэр шатахууны өглөгтэй гарсан байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтийг 1,024,598.0 мянган төгрөгөөр батлагдсан нь өмнөх оноос 107,462.3 мянган төгрөгөөр өссөн байна.

### **Бусад асуудал**

Тайлант онд 10 зорилт, 199 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 145 арга хэмжээ нь 85.0 хувиас дээш хэрэгжилттэй буюу бүрэн хангалттай, 14 арга хэмжээг 70-85 хувь буюу хангалттай, 40 арга хэмжээ 70.0 хувь хүртэл буюу хангалтгүй нийт дүнгээр 87.0 хувиар үнэлэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г. ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>298,094,415.93</b>	<b>327,168,715.93</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	23,876,806.00	23,876,806.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	23,876,806.00	23,876,806.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	23,876,806.00	23,876,806.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	270,499,109.93	303,291,909.93
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	81,912,521.93	81,332,521.93
35110	Тусгай зориулалттай материал	81,912,521.93	81,332,521.93
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	63,006,200.00	62,479,000.00
35410	Бичиг хэргийн материал	1,148,000.00	1,321,000.00
35420	Аж ахуйн материал	28,055,800.00	23,083,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,470,000.00	7,470,000.00
35440	Тулш, шатах тослох материал	245,000.00	245,000.00
35470	Бусад хангамжийн материал	26,087,400.00	30,359,400.00
35600	Мал амьтад	125,580,388.00	159,480,388.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	3,718,500.00	-
36200	Үрийн нөөц	3,718,500.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,669,015,113.35</b>	<b>2,084,907,954.28</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,669,015,113.35	2,084,907,954.28
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,528,696,113.35	1,867,802,704.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	749,458,078.26	749,458,078.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	(315,460,163.76)	(340,744,328.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	570,519,400.00	404,822,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(472,097,420.21)	(168,125,839.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	176,464,596.00	149,205,057.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(80,505,435.46)	(69,590,491.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	193,907,116.00	197,473,349.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,049,648.48)	(37,142,401.58)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,376,252,079.00	1,672,092,148.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(643,792,488.00)	(689,645,267.47)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	140,319,000.00	217,105,250.04
39301	Програм хангамж	1,112,500.00	286,250.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,112,500.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	140,319,000.00	220,819,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,999,999.96)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,967,109,529.28</b>	<b>2,412,076,670.21</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>318,751.00</b>	<b>8,328,050.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	318,751.00	8,328,050.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	318,751.00	8,328,050.00
41310	Ажлчидтай холбогдсон өглөг	318,751.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	8,328,050.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,966,790,778.28</b>	<b>2,403,748,620.21</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,966,790,778.28	2,403,748,620.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	574,441,392.63	574,441,392.63
51101	Өмч: - төрийн	574,441,392.63	574,441,392.63
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,208,419,336.84	1,645,377,178.77
51210	Өмнөх үеийн үр дүн	1,041,881,301.05	1,208,419,336.84
51220	Тайланг үеийн үр дүн	166,538,035.79	436,957,841.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	183,930,048.81	183,930,048.81
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,967,109,529.28</b>	<b>2,412,076,670.21</b>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,437,399,864.14</b>	<b>1,725,501,235.93</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>404,917,054.14</b>	<b>690,838,807.93</b>
120	<b>Нийтлэг тагварын бус орлого</b>	404,917,054.14	690,838,807.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,901,897.50	20,168,527.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	20,168,527.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,901,897.50	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	300,321,849.00	631,770,280.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	90,693,307.64	38,900,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,032,482,810.00</b>	<b>1,034,662,428.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	115,346,510.00	10,063,828.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	10,063,828.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,346,510.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	917,136,300.00	1,024,598,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	917,136,300.00	1,024,598,600.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,270,861,828.35</b>	<b>1,288,543,394.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,270,861,828.35</b>	<b>1,288,543,394.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,159,970,385.11	1,256,459,400.49
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	572,863,753.29	736,269,173.85
210101	Үндсэн цалин	276,010,009.75	430,217,021.51
210102	Нэмэгдэл	286,813,743.54	280,455,936.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,040,000.00	25,596,215.78
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,647,843.65	91,820,721.40
210201	Тэтгэврийн даатгал	49,872,269.36	66,483,089.90
210202	Тэтгэмжийн даатгал	6,151,217.29	6,325,552.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,245,866.33	3,198,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,066,460.13	3,162,775.50
210205	Эрүүл мэндийн даатгал	12,312,030.54	12,651,304.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,036,260.32	69,406,576.24
210301	Гэрэл, цахилгаан	5,371,650.32	10,910,016.24
210302	Түлш, халаалт	34,664,610.00	58,496,560.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	63,597,831.00	67,935,441.00
210401	Бичиг хэрэг	4,740,600.00	5,976,600.00
210402	Тээвэр, шатахуун	53,338,060.00	44,640,691.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,539,671.00	2,350,000.00
210404	Ном, хэвлэл	-	125,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	958,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,859,500.00	3,475,200.00
210408	Бараа материал акталсны зардал	-	10,408,700.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,060,000.00	17,051,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,160,000.00	-
210604	Урсгал засвар	900,000.00	17,051,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	7,098,000.00	10,685,000.00
210702	Дотоод албан томилолт	7,098,000.00	10,685,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	132,730,477.00	6,330,798.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	131,310,892.00	3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	850,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	126,927.00	540,264.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	852,658.00	890,534.00



Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	266,936,219.85	256,960,190.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,415,700.00	27,243,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	215,520,519.85	229,716,940.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,891,443.24	32,083,993.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,779,674.00	540,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,263,674.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,516,000.00	540,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	86,107,519.24	31,543,993.51
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,107,519.24	31,543,993.51
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,004,250.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,004,250.00	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>166,538,035.79</b>	<b>436,957,841.93</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>166,538,035.79</b>	<b>436,957,841.93</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,070,399,557.50</b>	<b>1,054,830,955.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,901,897.50</b>	<b>20,168,527.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	13,901,897.50	20,168,527.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	13,901,897.50	20,168,527.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	20,168,527.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,901,897.50	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,056,497,660.00</b>	<b>1,034,662,428.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	139,361,360.00	10,063,828.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,014,850.00	10,063,828.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,346,510.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	917,136,300.00	1,024,598,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	917,136,300.00	1,024,598,600.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,052,649,557.50</b>	<b>1,040,991,455.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,052,649,557.50</b>	<b>1,040,991,455.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>941,758,114.26</b>	<b>1,008,907,461.49</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	572,545,002.29	736,269,173.85
210101	Үндсэн цалин	276,010,009.75	430,217,021.51
210102	Нэмэгдэл	286,494,992.54	280,455,936.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,040,000.00	25,596,215.78
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,647,843.65	92,139,472.40
210201	Тэтгэврийн даатгал	49,872,269.36	66,801,840.90
210202	Тэтгэмжийн даатгал	6,151,217.29	6,325,552.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,245,866.33	3,198,000.00
210204	Ажигчидлийн даатгал	3,066,460.13	3,162,775.50
210205	Эрүүл мэндийн даатгал	12,312,030.54	12,651,304.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,566,260.32	69,406,576.24
210301	Гэрэл, цахилгаан	5,371,650.32	10,910,016.24
210302	Түлш, халаалт	36,194,610.00	58,496,560.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	60,173,281.00	43,393,511.00
210401	Бичиг хэрэг	5,538,600.00	6,174,600.00
210402	Тээвэр, шатахуун	45,657,510.00	32,860,461.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,539,671.00	2,350,000.00
210404	Ном, хэвлэл	275,000.00	125,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариунгал	1,920,000.00	958,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,242,500.00	924,200.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,674,300.00	17,356,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,697,000.00	-
210604	Урсгал засвар	20,977,300.00	17,356,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	7,098,000.00	10,685,000.00
210702	Дотоод албан томилолт	7,098,000.00	10,685,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	135,165,045.00	6,330,798.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,745,460.00	3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	850,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	126,927.00	540,264.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	852,658.00	890,534.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	26,888,382.00	33,326,430.00

Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,888,382.00	33,326,430.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	-
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>110,891,443.24</b>	<b>32,083,993.51</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,779,674.00	540,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,263,674.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,516,000.00	540,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	86,107,519.24	31,543,993.51
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,107,519.24	31,543,993.51
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,004,250.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,004,250.00	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>17,750,000.00</b>	<b>13,839,500.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,750,000.00	13,839,500.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>17,750,000.00</b>	<b>13,839,500.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	17,750,000.00	13,839,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,750,000.00	13,839,500.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(17,750,000.00)</b>	<b>(13,839,500.00)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>0.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,441,392.63	183,930,048.81	1,208,419,336.84	0.00	1,966,790,778.28
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	574,441,392.63	183,930,048.81	1,208,419,336.84	0.00	1,966,790,778.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	574,441,392.63	183,930,048.81	1,208,419,336.84	0.00	1,966,790,778.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өгз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	436,957,841.93	0.00	436,957,841.93
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,441,392.63	183,930,048.81	1,645,377,178.77	0.00	2,403,748,620.21

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,040,598,700.00	1,012,044,370.49	97%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,040,598,700.00	1,012,044,370.49	97%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,037,998,700.00	1,011,504,370.49	97%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	736,404,800.00	736,269,173.85	100%
210101	Үндсэн цалин	409,764,800.00	430,217,021.51	105%
210102	Нэмэгдэл	326,640,000.00	280,455,936.56	86%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	25,596,215.78	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	93,300,600.00	92,139,472.40	99%
210201	Тэтгэврийн даатгал	67,716,500.00	66,801,840.90	99%
210202	Тэтгэмжийн даатгал	6,396,000.00	6,325,552.00	99%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,198,000.00	3,198,000.00	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,198,000.00	3,162,775.50	99%
210205	Эрүүл мэндийн даатгал	12,792,100.00	12,651,304.00	99%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	69,797,000.00	69,406,576.24	99%
210301	Гэрэл, цахилгаан	11,000,000.00	10,910,016.24	99%
210302	Тулш, халаалт	58,497,000.00	58,496,560.00	100%
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	-	0%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	68,137,800.00	50,983,850.00	75%
210401	Бичиг хэрэг	13,464,000.00	8,724,600.00	65%
210402	Тээвэр, шатахуун	39,357,600.00	32,160,000.00	82%
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	2,400,000.00	2,200,000.00	92%
210404	Ном, хэвлэл	380,000.00	125,750.00	33%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ари	3,700,000.00	958,500.00	26%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,836,200.00	6,815,000.00	77%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,680,800.00	22,021,000.00	93%
210604	Урсгал засвар	23,680,800.00	22,021,000.00	93%
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	13,200,000.00	10,685,000.00	81%
210702	Догоод албан томилолт	13,200,000.00	10,685,000.00	81%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, х</b>	7,760,000.00	6,330,798.00	82%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээ	4,150,000.00	3,500,000.00	84%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700,000.00	-	0%
210803	Даатгалын үйлчилгээ	850,000.00	850,000.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600,000.00	540,264.00	90%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	440,000.00	98%
210807	Газрын төлбөр	900,000.00	890,534.00	99%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	25,717,700.00	23,668,500.00	92%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,717,700.00	23,668,500.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	-	0%
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,600,000.00	540,000.00	21%
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,600,000.00	540,000.00	21%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,600,000.00	540,000.00	21%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,040,598,000.00	1,013,223,370.49	97%
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,024,598,000.00	993,054,843.49	97%
132001	Орон нутгийн төсвөөс	1,024,598,000.00	993,054,843.49	97%
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	16,000,000.00	20,168,527.00	126%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	16,000,000.00	20,168,527.00	126%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эсийн үлдэгдэл	-	-	-

## 2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,242,828.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,242,828.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	11,242,591.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,215,661.00
210402	Тээвэр, шатахуун	700,461.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,365,200.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,026,930.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,026,930.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	237.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	237.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	11,242,828.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,242,828.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,462,328.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,780,500.00

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 1,027,625.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

### 3.1 Залруулсан алдаа

#### Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 176,136.4 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны үр дүнг 278,380.8 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд 101,116.8 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны санхүүжилт, 13,839.5 мянган төгрөгийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал, 122,652.2 мянган төгрөгийн урсгал зардлыг тус тус дутуу, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 27,637.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Санхүүгийн тайланд 623.0 мянган төгрөгийн орлого бууруулах бичилт хийсэн зэрэг бүртгэлийн алдааг нягталж залруулсан.
- Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр хэсэгт мэдээлбэл зохих 105,617.2 мянган төгрөгийн 53 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ болох 52,395.0 мянган төгрөгийн 4 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ болох 149,226.6 мянган төгрөгийн 6 гүйлгээ, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

шийдвэр хэсэгт шийдвэрийн хуулбар тус тус мэдээлээгүй байсныг аудитын хугацаанд нөхөн мэдээлүүлсэн.

Залруулагдаагүй нийт 62,407.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн. Аймгийн Засаг даргад 43,077.8 мянган төгрөгийн, сумын Засаг даргад 5,100.0 мянган төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлж, төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитын дүгнэлтэд авч үзэхээр шийдвэрлэсэн.

Аудитаар нийт 62,407.5 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах 5 зөвлөмж өгсөн.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### ***Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой***

1. Илрүүлэлт: Нягтлан бодогч байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогын тооцоог бодоогүй, тооллогын комисс үндсэн хөрөнгийн тооллогыг нэр төдий бөөн дүнгээр тоолсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллого хийсэн тухай бүр тооцоог бодож, хөрөнгийг нэр төрлөөр тоолж байх.

#### ***Хоёр. Үндсэн үйл ажиллагааны орлоготой холбоотой***

Тайлант онд буудлын орлого болох 1,179.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг байгууллагын үндсэн дансанд төвлөрүүлэлгүй, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын өөрийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг төлөвлөн, үндсэн дансаар дамжуулан журмын дагуу зарцуулах.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### **Гурав. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой**

Тайлант онд 5,100.0 мянган төгрөгөөр гамшгийн бэлэн байдлын хувцас бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зориулалтын дагуу зарцуулан, хууль тогтоомжоор хориглосон зардалд зарцуулахгүй байх.

### **Дөрөв. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа боловч төрийн албаны шалгалт өгөөгүй түр томилгоотой албан хаагчдад 13,050.7 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам" -ын 2 дугаар зүйлийн 2.3-т "Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн захиргааны албан тушаалд түр ажиллаж байгаа ажилтанд нэмэгдэл цалин олгож байгаа зөрчлийг таслан зогсоох.

Тайлант оны 12 дугаар сард 2025 оны төсвийн төсөлд тусгаагүй 17,424.0 мянган төгрөгийн хоолны нөхөх төлбөр, 25,653.8 мянган төгрөгийн урамшууллын зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн төлөвлөлтийг бодитой тооцоотой хийж батлуулан ажиллагсадтай холбоотой зардлыг төсөвт тусгасны дагуу олгох, төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Дөрөв. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**  
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллын нэр	Алдааны утга	(мянган төгрөгөөр)											
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:		Запруулааг үй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2		3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 176,136.4 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны үр дүнг 278,380.8 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.		1	454,517.2	-	-	1	454,517.2	1	454,517.2	-	-	-	-
Мөнгөн гүйлгээний тайланд 101,116.8 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны санхүүжилт, 13,839.5 мянган төгрөгийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал, 122,652.2 мянган төгрөгийн урсгал зардлыг тус тус дутуу, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 27,637.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан		1	265,246.1	-	-	1	265,246.1	1	265,246.1	-	-	-	-
Санхүүгийн тайланд 623.0 мянган төгрөгийн орлого бууруулах бичилт хийсэн		1	623.0			1	623.0	1	623.0	-	-	-	-
Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр хэсэгт мэдээлбэл зохих 105,617.2 мянган төгрөгийн 53 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ болох 52,395.0 мянган төгрөгийн 4 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ болох 149,226.6 мянган төгрөгийн 6 гүйлгээ, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт шийдвэрийн хуулбар тус тус мэдээлээгүй байна.		1	307,238.9	1	307,238.9	-	-	1	307,238.9	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>1,027,625.2</b>	<b>1</b>	<b>307,238.9</b>	<b>3</b>	<b>720,386.3</b>	<b>4</b>	<b>1,027,625.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:						ХХБ-д шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүн зөрүүтэй, тооцоог бодоогүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
	Тайлант онд байгууллагын эзэмшлийн буудлын орлого 1,179.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг байгууллагын үндсэн дансанд төвлөрүүлэлгүй, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.	1	1,179.0	-	-	-	-	1	1,179.0	-	-
Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг даргын Тамгын газар	Тайлант оны 12 дугаар сард 2025 оны төсвийн төсөлд тусгаагүй 17,424.0 мянган төгрөгийн хоолны нөхөн төлбөр, 25,653.8 мянган төгрөгийн урамшууллын зардал гаргасан	1	43,077.8	-	-	-	-	1	43,077.8	-	-
	Тайлант онд 5,100.0 мянган төгрөгөөр гамшгийн бэлэн байдлын хувцас бэлтгэсэн	1	5,100.0	-	-	-	-	1	5,100.0	-	-
	Төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа боловч төрийн албаны шалгалт өгөөгүй түр томилгоотой албан хаагчдад 13,050.7 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон	1	13,050.7	-	-	-	-	1	13,050.7	-	-
	<b>ДҮН</b>	<b>5</b>	<b>62,407.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>62,407.5</b>	<b>-</b>	<b>-</b>



Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтий	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	<b>НИЙТ</b>		<b>1</b>				<b>1</b>		

ГАА-2026/066/НА-СТА-ТШЗ

